



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 5 сарын 08 өдөр

Дугаар 101

Улаанбаатар хот

### Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.8, 6.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Өндөрхаан инвест ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 45,000,000 /дөчин таван сая/ төгрөгөөр нэмэгдүүлж хавсралтад заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Өндөрхаан инвест ҮЦК” ХХК /Н.Оюунтунгалаг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН



Санхүүгийн зохицуулах хорооны  
2019 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн  
10 дүгээр тогтоолын хавсралт

“Өндөрхаан инвест ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн  
хөрөнгийн хэмжээнд оруулах өөрчлөлт

№	Хувьцаа эзэмшигчийн нэр, /Регистрийн дугаар/	Хувьцааны нэрлэсэн үнэ/₮/	Хувьцааны эхний үлдэгдэл			Өөрчлөлт		Хувьцааны эцсийн үлдэгдэл		
			Тоо ширхэг	Үнийн дүн/₮/	Эзлэх хувь /%/	Тоо ширхэг	Үнийн дүн/₮/	Тоо ширхэг	Үнийн дүн/₮/	Эзлэх хувь /%/
1	Н.Оюунтунгалаг /РД:СЭ68040666/	1000₮	55,000	55,000,000	100%	45,000	45,000,000	100,000	100,000,000	100%
	Нийт		55,000	55,000,000	100%	45,000	45,000,000	100,000	100,000,000	100%